

БАЯНЗАГ


МОНГОЛЫН ДЭЛХИЙД АЛДАРТАЙ ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОРТ ГАЗАР

Баянзаг нь Өмнөговь аймгийн нутагт оршдог, орон нутгийн хамгаалалтай парк бөгөөд дэлхийд алдаршсан динозаврын ховор олдвортой юм. Хэрэв та энэ паркт ирж, тухлан зочилбол байгалийнх нь унаган төрх, амьтан, ургамал, ховор олдворуудыг хөндөж гэмтээхгүй байх хэрэгтэй. Учир нь энэ ховор байгалийн цогц бүхий парк нь зөвхөн Монголд төдийгүй дэлхийн шинжлэх ухаанд чухал газар нутаг юм.

80 САЯ ЖИЛИЙН ӨМНӨ ЯМАР АМЬТАД АМЬДАРЧ БАЙСАН БЭ?

Энэ үе нь Цэрдийн галав буюу динозаврууд дэлхийд амьдарч байсан сүүлчийн цаг хугацаа байлаа.

Баянзагийн цонжнууд нь тэр үеийн булаг, цөөрөмтэй элсэн манханууд байсан ба тэнд амьтад ан хийж, хоол хүнс хайх, үр зулзагаа өсгөдөг газар байжээ. Эдгээрээс та бүхэнд гурван амьтныг нь төлөөлөн танилцуулъя.



Анх 1923 онд

Баянзагаас олдсон энэ

өвсөн тэжээлтэн динозавр *Пинакозавр* нь ойролцоогоор 2 тонн жинтэй, бие нь ясан хуягаар бүрхэгдсэн амьтан байлаа.

1922 онд Баянзагаас олдсон

өвсөн тэжээлтэн динозавр

Протоцератопс

нь Монголоос олдсон хамгийн анхны динозавр байсан бөгөөд биеийн хэмжээгээр хониноос томгүй байжээ.



“Юрийн Парк” кинонд гарч алдартай болсон динозавр *Велоцирантор* нь анх 1924 онд Баянзагаас олдсон бөгөөд хурц хумстай, 2 метр орчим урт, шувуу шиг өдтэй амьтан байжээ. Мөн *Протоцератопсыг* агнаж иддэг байсан байна.



БАЙГАЛИЙН ЭМЗЭГ ЭКОЛОГИЙН СИСТЕМ

Манай говь цөл нь дэлхийн аль ч газар байхгүй ховор амьтан, ургамал амьдардаг байгалийн сонирхолтой газар нутаг юм. Тиймээс Баянзагийн амьд экологийн системийг динозавр шиг сөнөж үгүй болохоос сэргийлж дараахь дүрэм журмыг даган, хэвшил болгоно уу.

Хайлаас мод, заг, ургамлыг эвдэж сүйтгэж болохгүй, мөн цуглуулахгүй байх.

Зэрлэг амьтанд идэх юм өгөхгүй байх мөн айлгаж гэмтээж болохгүй.

Хог хаяхгүй, цуглуулан өөрсдөө авч явах.



ОЛДВОР ОЛБОЛ ЯАХ ВЭ?

1

Гар хүрч гэмтээхгүй байх. Хэрэв гар хүрч гэмтээвэл шинжлэх ухаанд хэрэгтэй мэдлэг, мэдээлэлийг авах боломжгүй болдог. Түүнээс гадна тусгай зөвшөөрөлгүйгээр олдворыг цуглуулах нь хууль бус үйл ажиллагаа гэдгийг анхаарна уу.

2

Хэрэв та олдвор олбол Өмнөговь аймгийн байгаль хамгаалагч нарт мөн орон нутгийн засаг захиргаанд заавал мэдэгдэх хэрэгтэй.

3

Түүнээс гадна Монголын Динозавр Судлалын Хүрээлэнгийн доорхи цахим хуудас руу орж олдворын зургийг нь явуулахаас гадна байршлыг нь мэдэгдэнэ үү. MongolianDinosaurs.org. Орон нутагт хууль бус ухалт хийсэн тохиолдлууд гарсан байгаа тиймээс олсон газраа албаны бус хүнтэй хуваалцахгүй байх.



Мэдээлэлийг бэлтгэсэн Монголын Динозавр Судлалын Хүрээлэн ТББ (Institute for the Study of Mongolian Dinosaurs). Тус байгууллага нь АНУ болон Монголд албан ёсны бүртгэлтэй. MongolianDinosaurs.org